

ДААТГАЛЫН МЭДЭЭ

2010 оны 8 дугаар сар

1. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ:

2010 оны 8 дугаар сарын байдлаар даатгалын салбарт үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон тусгай зөвшөөрөлд орсон өөрчлөлтүүд дараах байдалтай байна:

/тоогоор/					
№	Тусгай зөвшөөрөл эзэмшигчид, өөрчлөлт	2010-VII	Нэмэгдсэн	Хасагдсан	2010-VIII
1	Даатгалын компани	16			16
2	Даатгалын компанийн салбар	136			136
3	Даатгалын төлөөлөгч	1962	36 ¹		1998
4	Даатгалын зуучлагч	8			8
5	Даатгалын хохирол үнэлэгч	6			6
6	Актуарч	10			10
7	Аудитын компани	20			20
8	Аудитор	46			46

Тайлант үед даатгалын компани, тэдгээрийн салбар, даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгч, актуарч, аудитын компани болон аудиторуудын тоонд өөрчлөлт ороогүй байна.

¹Хорооны даргын 2010 оны 8 дугаар сарын 03-ны өдрийн 119 дүгээр тушаалаар “Монгол даатгал” ХХК-ийн 27 даатгалын төлөөлөгчид, 121 дүгээр тушаалаар “Нэйшнл лайф даатгал” ХХК-ийн 9 даатгалын төлөөлөгчид үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгосноор даатгалын төлөөлөгчийн тоо 2010 оны 8 дугаар сарын байдлаар 1998 болсон байна.

2. САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ:


Даатгалын байгууллагуудын 2010 оны 8 дугаар сарын даатгалын үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдийг 2009 оны мөн үеийнхтэй харьцуулбал:

Ердийн даатгалын компаниудын хувьд :

/төгрөгөөр/			
№	Үзүүлэлт	2009-VIII	2010-VIII
1	Даатгалын нийт хураамж	2,148,035,373.2	2,134,617,264.8
2	Олгосон нийт нөхөн төлбөр	364,994,759.0	505,511,092.1

3	Давхар даатгалд төлсөн хураамж	785,354,225.0	863,038,675.0
4	Байгуулсан даатгалын гэрээний тоо /ширхэг/	4,689	6,425
5	Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	3,142,308,550.0	101,790,000,000.0
6	Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн	45,000,000.0	44,571,980.0

Даатгалын компаниудын даатгалын хураамжийн орлого, нөхөн төлбөр, давхар даатгалд төлсөн хураамж, сая төгрөгөөр



2010 оны 8 дугаар сард даатгалын компаниудын төвлөрүүлсэн даатгалын нийт хураамжийн орлого нь өмнөх оны мөн үеийнхээс 13.4 сая төгрөгөөр буурч, давхар даатгалд төлсөн хураамж 77.6 сая төгрөгөөр, олгосон даатгалын нөхөн төлбөр 140.5 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

Тайлант үед шилжүүлсэн давхар даатгалын хураамжийн 64.3 хувь буюу 555.3 сая төгрөгийг “Бодь даатгал” ХХК, 25.3 хувь буюу 219.1 сая төгрөгийг “Монгол даатгал” ХХК, бусад 10.4 хувь буюу 88.4 сая төгрөгийг “Миг даатгал” ХХК, “Ард даатгал” ХХК шилжүүлсэн байна.

Урт хугацааны даатгалын компанийн хувьд :

№	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2009-VIII	2010-VIII
1	Даатгалын нийт хураамж	3,566,247.00	80,475,539.43
2	Олгосон нийт нөхөн төлбөр	792,000.00	3,125,262.00
3	Давхар даатгалд төлсөн хураамж	3,816,265.50	-
4	Байгуулсан даатгалын гэрээний тоо	8	8

	Үүнээс: -Хувь хүний хугацаат даатгалд		3
	-Байгууллагын хугацаат даатгалд		4
	-Өндөр хамгаалалттай ЭМД-д		1
5	Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	100,000,000.00	100,000,000.00
6	Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн	540,000.00	560,000.00

“Нэйшнл лайф даатгал” ХХК-ийн 2010 оны 8 дугаар сарын даатгалын хураамжийн орлого болон нөхөн төлбөрийг 2009 оны мөн үеийнхтэй харьцуулж үзэхэд даатгалын хураамжийн орлого 76.9 сая төгрөгөөр буюу 2197.0 хувиар, нөхөн төлбөр 2.3 сая төгрөгөөр буюу 294.0 хувиар тус тус нэмэгдсэн байна.

Даатгалын зуучлагч компаниудын хувьд :

№	Үзүүлэлт	/төгрөгөөр/		
		2010-VI	2010-VII	2010-VIII
1	Даатгуулагчаас шууд орж ирсэн даатгалын хураамж	29,465,076.4	31,686,601.0	40,106,149.5
2	Даатгалын зуучлагчийн орлого	16,515,077.7	13,987,318.7	18,341,972.8
3	Зуучилсан даатгалын гэрээний тоо	143	302	22
4	Зуучилсан даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	3,009,477,842.0	10,487,981,062.0	15,959,225,000.0

2010 оны 8 дугаар сарын байдлаар даатгалын зуучлагч компаниуд 22 даатгалын гэрээг даатгалын компаниудад зуучлан 18.3 сая төгрөгийн зуучлалын орлого олсон байна.